



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 02

Хэргэн сум

Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах  
төлөвлөгөөний тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48.1, Компанийн дүрмийн 7.13.5, 7.13.6 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 тоот тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Эрчим хүчний сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/20 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг дэмжсүгэй.
2. Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг холбогдох хууль, журмын дагуу баталж, Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхийг /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.
3. Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2022 оны 01 дүгээр сарын 10ны өдрийн дотор байршуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган биелэлтийг улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж байхыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /Г.Пүрэвдорж/-д даалгасугай.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ ЭХХНИЙ  
ТӨЛӨӨЛӨН  
ЗӨВЛӨЛ  
ТТР0374 - 2628651  
ДОРНОД АЙМАГ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 02

Хэрлэн сум

Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгийн  
нэмэгдлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3.17, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамтын хэлэлцээрийн 3.6, Захиргаа үйлдвэрчний эвлэлийн хооронд байгуулсан хамтын гэрээний 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан аудитын байгууллагаар баталгаажаагүй тул техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг харгалзан жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдлээс 1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг олгохыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин, урамшууллын хороо (Г.Бадамцэцэг)-нд үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ-ӨХ-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН  
ЗӨВЛӨЛ  
ДОРНОД БҮСИЙН  
ТТР0374 - 2628651  
ДОРНОД АЙМАГ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 03

Хэргэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны ажлын  
төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 9.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн тогтоосон хугацаанд хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт, хурлыг тухай бүр журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Нарантуяад тус тус даалгасугай.

ДАРГА  Г.ЖАНАРБААТАР



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 02 дугаар сарын 2-ны  
өдрийн 7 дүгээр тогтоолын хавсралт



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын үзүүлэлт	2022 төлөвлөгөө (мян.төг)			
		Хүн	Тарифт	Сард	Жилд
1	<b>1. Цалингийн зардал</b>	<b>10</b>		<b>5,520.0</b>	<b>83,400.0</b>
1.2	ТУЗ-ын дарга	1	750,000	750.0	9,000.0
1.3	Гишүүд	8	700,000	5,600.0	67,200.0
1.4	Нарийн бичгийн дарга	1	600,000	600.0	7,200.0
2	<b>2. НДШ</b>			<b>1,753.49</b>	<b>12,093.0</b>
3	<b>3. Томилолтын зардал</b>			-	<b>6,564.6</b>
3.1	Унаа	9	214,700	1,932.3	3,864.6
3.2	Байр, хоол /хүн-хоног/	9	50,000	1,350.0	2,700.0
4	<b>4. Бичиг хэрэг</b>			<b>20.0</b>	<b>240.0</b>
4.1	Бичиг хэрэг			20.00	240.00
5	<b>5. Хурлын зардал</b>			60.00	660.00
	<b>ДҮН</b>			<b>8,579.8</b>	<b>102,957.6</b>





“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 04

Хөдлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны  
зардлын төсвийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг 102,975,600 /нэг зуун хоёр сая есөн зуун далан таван мянга зургаан зуу/ төгрөгөөр тогтоож, хавсралт ёсоор дэмжсүгэй.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА *М.Ариунтөв* Ж.ЖАНАРБААТАР





“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хурлын 01 дүгээр тэмдэглэлд:

1. **ХЭЛЭЛЦСЭН** нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны ажлын тайлан

**ШИЙДВЭРЛЭСЭН** нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны тогтоол, шийдвэрийн биелэлт, ажлын тайланг тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Нарантуяа)-д тус тус даалгав” гэжээ.

ДАРГА  Ж.ЖАНАРБААТАР





“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 05

Хэрлэн сум

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан  
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 62.1.9, 62.1.15, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14.00 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Насантогтохыг сонгосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 3 дугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

4. Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Тооллогын комиссын дарга: А.Мэндсайхан /ХХХ-ийн мэргэжилтэн/

Гишүүд: Л.Уугантуяа /Төлөвлөлтийн эдийн засагч/

О.Нармандах /ХНСХ мэргэжилтэн/

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах өдрийг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр тус тус тогтоосугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР

580222005





“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 7

Хэрлэн сум

Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/584 тоот албан бичгээр ирүүлсэн аудитын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 51,828,248,437.98 төгрөгийн орлоготой, 51,093,686,979.97 төгрөгийн зардалтай, 688,385,135.49 төгрөгийн ашигтай ажиллаж зорилтот түвшинг ханган биелүүлсэн, мөн Үндэсний аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” гэсэн дүгнэлт өгсөн тул компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийн хамт хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт тус тус үүрэг болгосугай.

3. Үндэсний аудитын газрын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, биелэлтийг хагас жил тутам Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгасугай.


ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



"ДБЭХС" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 8 дугаар тогтоолын хавсралт



"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН 2021 ОНЫ КОНТРАТЫН БИЕЛЭЛТ

д/д	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2021 он		Төлөвлөгөөтэй		Оноо	
			төлөв	гүйц	зөрүү	хувь	Авбал зохих	Авсан
1	<b>Эдийн засгийн үзүүлэлт</b>							
1	Боловсруулсан ЦЭХ	сая. кВтц	233.5	245.6	12.1	105.2	5	5
2	Нийт түгээх ЦЭХ	сая. кВтц	261.0	281.6	20.6	107.9		
	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	201.1	212.0	10.9	105.4		
	ХАЦЭХ	сая. кВтц	59.7	69.5	9.8	116.4		
	Импортын ЦЭХ	сая. кВтц	0.255	0.202	(0.1)	79.3		
3	Түгээлт ДЭХ	мян.Гкал	302.4	322.8	20.4	106.8		
4	Дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч	хувь	13.9%	13.7%	-0.2%	101.2	5	5
5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	8.1%	5.4%	-2.7%	150.0		
6	Нийт орлого	сая.төг	49,435.9	51,840.7	2,404.8	104.9	5	5
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая.төг	47,968.6	50,422.7	2,454.1	105.1		
7	Нийт зардал	сая.төг	49,220.9	51,106.1	1,885.3	103.8	5	5
	Үүнээс : Удирдлагын зардал	сая.төг	328	323	(4.3)	98.7		
	Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	215.0	734.6	519.5	341.6		
8	ААНОАТатвар	сая.төг	-	46.2	46.2	0.0	10	10
	Цэвэр ашиг /алдагдал /	сая.төг	215.0	688.4	473.4	320.1		
9	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл, улс орон нутгийн төсөвт өр төлбөргүй	сая.төг	45.4	45.4	-	0.0	5	5
10	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.996	0.986	(0.0)	99.0	5	5
11	Нийт авлага	сая.төг	77.0	2,822.5	2,745.5	3665.5	5	5
12	Нийт өглөг	сая.төг	9,797.4	30,396.4	20,599.0	310.3	5	5
	Үүнээс : Богино хугацаат өглөг	сая.төг	2,450.0	3,280.4	830.4	133.9		
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	6,686.8	5,548.5	(1,138.3)	83.0	5	5
14	Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	гр/кВтц	641.8	640.6	(1.1)	100.2	5	5
	ДЭХ	кг/Гкал	193.0	192.1	(0.9)	100.5		
2	<b>Тайлангийн үр дүн</b>							
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт						6	6
2.2	Захирлын ажлын тайлан						2	2
2.3	Шийдвэрийн хэрэгжилт / ЭХЯ, ТӨБЗГ/						5	5
2.4	Худалдан авах ажиллагааны тухай хууль, шилэн дасны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт						5	3
3	<b>Үйлдвэрлэлийн осол аваарь, 1.2 дугаар зэргийн саатал</b>						15	15
	<b>ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮН</b>						<b>93</b>	<b>91</b>
4	Хэрэглэгчийн санал асуулгын дүн						3	3
5	Ажиллагсдын санал асуулгын дүн						4	4
	<b>НИЙТ ДҮН</b>						<b>100</b>	<b>98.0</b>



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 8

Хэрлэн сум

Г Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын  
үүргийн биелэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, 83 дугаар зүйлийн 83.6 дахь хэсэг, “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам”-ын 2.4, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.12 дахь заалт, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарын 2021 онд Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан контрактын биелэлтийг хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарын 2021 оны контрактын биелэлтийг 98 оноогоор “Сайн” гэж дүгнэсүгэй.
3. Компанийн гүйцэтгэх захирлын контрактын биелэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 9

Хэрлэн сум

Г Ногдол ашиг хуваарилах тухай Г

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.8, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 4.1, 7.3.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК нь 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр 688,385,135.49 (зургаан зуун наян найман сая гурван зуун наян таван мянга нэг зуун гучин таван төгрөг дөчин есөн мөнгө) төгрөгийн ашигтай ажилласан тул цэвэр ашгийн 15 хувиар тооцож компанийн хувьцаа эзэмшигчдэд 103,257,770.3 (нэг зуун гурван сая хоёр зуун тавин долоон мянга долоон зуун далан төгрөг гучин мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг дэмжсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Г.Пүрэвдорж/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  ЖАНАРБААТАР

ЭРЧИМ ХҮЧНИЙ  
СИСТЕМ  
ТӨЛӨӨЛӨН  
ЗӨВЛӨЛ  
ТТР0374 ± 2628651  
ДОРНОД АЙМАГ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 10

Хэрлэн сум

Нэр дэвшүүлэх түр хороо  
байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Нэр дэвшүүлэх түр хорооны дарга:

1. Б.Пунцагбалжир

Нэр дэвшүүлэх түр хорооны гишүүд:

2. О.Бүжин
3. В.Дарханбаатар

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг Нэр дэвшүүлэх түр хороо /Б.Пунцагбалжир/-нд даагасугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР